

(ШҮҮМЖ)

В. А. Богословский**ТИБЕТСКИЙ РАЙОН КНР. М., 1978, 198 с.**

Өөрийн өвөрмөц төрийн байгууламж, түүх, соёл, шашинтай Төвд орон эрт дээр үеэс төвд судлаачдын анхаарлыг татсаар ирсэн ба өнөөдөр хятад дахь үндэсний асуудлын үүднээс анхаарал татаж байна.

1978 онд зөвлөлтийн «Наука» хэвлэлийн газраас эрхлэн зөвлөлтийн төвдөч эрдэмтэн В. А. Богословскийн бичсэн «БНХАУ-ын Төвдийн Район» (1949—1976) гэсэн нэгэн сэдэвт бүтээлийг хэвлэн гаргажээ.

Энэ номыг зохиогч зөвлөлтийн эрдэмтэн В. А. Богословский бол олон жилийн туршид Төвдийн түүх, нийгэм-эдийн засаг, улс төрийн хөгжилтийг судалж байгаа нэрд гарсан төвд судлаач юм.

В. А. Богословскийн эрдэм шинжилгээний өндөр түвшинд бичсэн, гүн гүнзгий утга агуулга бүхий олон бүтээлийг төвд судлаачид сайн мэднэ. Тухайлбал «Төвдийн ард түмний товч түүх» 1962 он, Төвд ба «Соёлын хувьсгал», 1975 он, «Төвд дахь шарын шашны сүм хийд тэдгээрийн өнөөгийн байдал» 1976 он, «Төвд дахь газрын шинэчлэл» (1959-64), зэрэг ном, зохиол өгүүллийг манай түүхчид, Төвд судлаачид өндөр үнэлж, заримыг нь монгол хэлнээ орчуулан нийтэлж байна. 1949 онд БНХАУ байгуулагдаж түүний бүрэлдэхүүнд багтсан хятад биш үндэстнүүдийн нийгэм-улс төр, эдийн засгийн амьдралд хувьсгалын эхний жилүүдэд нилээд өөрчлөлт гарсан нь эргэлзээгүй. Гэхдээ тавиад оны сүүлчээс БНХАУ-ын үндэсний автономит районуудын дотор хан үндэстний дээрэнгүй үзэл хүчтэй болохын сацуугаар хятад бус үндэстний эсэргүүцэл тэмцэл өрнөж оршин суугчид нутаг орноо орхин гадаадад дүрвэн гарахад хүрдэг байлаа.

Зохиогч Хятадын удирдлага Төвдийг БНХАУ-ын хүрээнд нэгтгэн авч Төвдөд Бээжингийн эрх баригчдын үндэсний бодлогыг хэрэгжүүлсэн арга замыг марксист-ленинист түүхэн шинжлэх ухааны зарчим дээр баялаг материал ашиглан судалж дүн шинжилгээ хийсэн байна.

Богословскийн эрдэм шинжилгээний энэ бүтээл нь «Төвд орон хэзээнээсээ Хятадын бүрэлдэхүүнд багтаж ирсэн» гэдэг хятадын эртний болон өнөөгийн маоист түүхчид, Төвдийн ард түмэн өөрийн түүхээ бүтээж чадахгүй мэтээр үзэж Төвдийн түүхийг мушгин гуйвуулж, хятадын эзэн хаад, харгис гоминьданы «эзэн эрх» гэгчийг Төвдийн хувьд хүлээн зөвшөөрсөөр байгаа хөрөнгөтний түүхчдийн баримталдаг байр суурьт зохих няцаалт болох нь дамжиггүй.

Хятадын удирдлага хэрхэн ямар арга, заль мэхээр БНХАУ-ын хүрээнд Төвдийг татан оруулж авсан хийгээд Бээжингээс Төвдөд хэрэгжүүлсэн нийгэм-эдийн засаг, улс төрийн бодлогыг Төвдийн янз бүрийн давхарга ямар шүү байдлаар хүлээн авсныг судлан дүн шинжилгээ хийхэд зохиолын гол зорилт оршино. Энэ зорилтыг зохиогч номдоо амжилттай шийдвэрлэж ХКН-ын доторхи маоист удирдлагын Төвдийн районд хэрэгжүүлсэн үндэсний бодлогын мөн чанарыг өнөөгийн Төвдийн Автономит Районы бодит байдал дээр харуулжээ.

Зохиогч 195-59 оны хоорондох Төвдийн нийгэм-эдийн засаг, улс төрийн харьцааны шинж чанар, 1959-65 онд Төвдөд хийсэн «шинэчлэлүүд», «Соёлын хувьсгал» зэрэгт нарийн дүн шинжилгээ хийж судалсан байна.

Ийнхүү ХКН-аас 30 шахам жилийн туршид Төвдийн талаар явуулж ирсэн хятадчилан уусгах бодлогыг марксист-ленинист үндэсний бодлогын үүднээс дүн шинжилгээ хийсэн нь зохиогчоос орчин үеийн дорно дахины судлал, тухайлбал, Төвдийн судлалд оруулсан жинтэй хувь нэмэр болно.

Хятадад ардын хувьсгал ялахаас өмнө биеэ даасан тусгаар улсын байдалтай байж (14-15-р тал) Төвдийн ард түмэн төр улсаа удирдах төрийн байгууламжаа олон зуун жилийн туршид өөрсдөө боловсруулан боловсронгуй болгон, өөрийн уламжлалт соёлоо хөгжүүлж ирсэн байна. Гэтэл хятадын маоист удирдлага Төвдийн түүхэн тусгаар байдал, өвөрмөц соёл, шашин, түүхийг мушгин гуйвуулж, Төвд орон эрт дээр цагаас Хятадын бүрэлдэхүүнд багтаж ирсэн гэх буюу, тун эс болбол Төвд Хятадаас хараат байдалд байсан (27-28-р тал) гэж нотлохыг оролдсоор байна. Эдгээр асуудлыг зохиогч хөндөн тавьж дэс дараатайгаар шинжлэн судлаад «Өнөөгийн Хятадын түүх судлал, үнэн хэрэгтээ Төвдүүд өөрийн улс төр, нийгмийн байгууламжийг цогцлон байгуулах авьяас билэггүй бөгөөд тэдгээрийг хятадууд буй болгож өгсөн» гэх буюу (28-р тал), «Төвдийн соёл ч гэсэн хятадын соёлын шийдвэрлэх нөлөөн дор буй болсон» гэж нотлохыг оролдож байгаа Бээжингийн удирдагчдын бодлогын үндэсгүй болохыг түүхэн баримтаар няцаажээ (30-р тал). 1951 оны 5-р сарын 23-нд Хятадын удирдлага «Төвдийг тайван замаар чөлөөлөх арга хэмжээнүүдийн тухай» 17 зүйлт хэлэлцээрийн бэлэн төслийг Төвдийн орон нутгийн засгийн газарт тулган хүлээлгэж гарын үсэг зуруулснаар Төвдийг БНХАУ-ын бүрэлдэхүүнд нэгтгэх бодлого үе шат дараалан хэрэгжиж эхлэсэн билээ. Чухам 1951 оны хэлэлцээрээс 1959 оны 3-р сард Төвдийн ард түмнээс хятадын бодлогыг эсэргүүцэж гарсан бослогыг хүртэлх хугацааны Төвд, Хятадын харилцаа, хятадын эрх баригчдаас Төвдийн нийгмийн дээд давхаргатай холбоо тогтоох замаар Төвдийн Далай ламын засгийн газар, орон нутгийн засаг захиргааг устгаж хятадчилах талаар Бээжингийн явуулсан бодлогод Богословский баялаг материал дээр тулгуурлан нарийн судалгаа явуулжээ. (2-р бүлэг). Бээжингийн удирдлага 1951 оны хэлэлцээрээр хүлээсэн Төвдийн орон нутгийн засгийн газрын үйл ажиллагааг хэвээр үргэлжлүүлэн, сүм хийдийн үйл ажиллагаанд саад хийхгүй байх, шашин шүтлэгийн эрх чөлөөг хүндэтгэх тухай амлалтаасаа няцаж 1959 оны 3-р сарын бослогыг Төвдийн орон нутгийн засгийн газар зохион байгуулсан гэдэг нэрийн дор түүнийг Хятадын АЧА-ийн анги салбарын шууд оролцоотойгоор устгах үйл ажиллагаанд шилжжээ.

Ийнхүү 1959 оны 3-р сарын Зэвсэгт бослогыг харгислан дарсны дараа Бээжингийн удирдлага Төвдийн нийгэмд нийгэм-эдийн засаг, улс төрийн өөрчлөлт хийж, Төвдийн районыг БНХАУ-ын бүрэлдэхүүнд нэгтгэх үйл явцыг цаашид үргэлжлүүлэх боломжтой болж Бээжингээс Төвдөд явуулах үндэсний бодлогод их хан үндэстний үндсэрхэх дээрэнгүй үзэл улам бүр газар авсан тухай зохиогч иш баримттайгаар цохон тэмдэглэсэн байна. (94-95-р тал).

Хятадын удирдлага төвд үндэстнийг хан үндэстэнд уусган нийлүүлэх хэтийн зорилгодоо захирагдан Төвдийн Автономит Районыг байгуулахад Цинхай, Сычуань, Ганьсу, Юньнань мужуудад оршин суугаа шашин, зан уламжлал, нэг соёлтой төвд үндэстнүүдийг энэ автономит районы бүрэлдэхүүнд оруулаагүй ажээ. Гэтэл өнөөдөр Бээжингийн эрх баригчид дээрх

хятад мужуудад оршин суугаа Төвд үндэстнүүдийг хан үндэстэн гэж нэрлэх болжээ. Энэ бол уусган нийлүүлэх Бээжингийн бодлогын нэг тодорхой жишээ юм.

1959-65 онд хийгдсэн «Төвд дэх шинэчлэл»-ийн явцад төвдийн феодалуудын газар болон үйлвэрийн багаж хэрэгслийг эзэмших эрхийг устгаж, тариачид (үйлдвэрлэгчид) феодал газар эзэмшигчдээс хараат байх явдлыг зогсоож, Төвдийн хөдөө аж ахуйг аажмаар хоршоолж эхлэсэн нь Төвдийн хуучин нийгмийн байгууламжийг устгах, нийгмийн шинэ харьцаа бий болгох, улмаар төвдийн тариачдын хүнд хүчир хөдөлмөр феодалын зүгээс тэдэнд үзүүлж байсан дарамт, дарлал мөлжлөгийг арилган, тариачдын аж байдлын түвшинг дээшлүүлэхэд гол хүчин зүйл болох ёстой байсан билээ. Гэтэл маогийнхны үндэсний алдаатай бодлогын хор уршгаар Төвдөд хийгдсэн бүх төрлийн «шинэчлэлтүүдийн» гол зорилго нь дээрх зангилаа асуудлыг шийдвэрлэхэд бус харин Төвдийг «Хятад үндэстэн оршин суудаг хятадын бусад мужуудынх шиг тийм нийгмийн бүтцийг Төвдөд бий болгох явдал байсан» тухай зохиогч дүгнэн бичжээ. Тийм ч учраас Төвдөд албадан хэрэгжүүлж байсан тэрхүү «шинэчлэлийн» бодлого нь цаг ямагт төвдийн янз бүрийн давхаргын эсэргүүцэл дургүйцэлтэй тулгарч байсныг зохиолд тодорхой харуулжээ.

Төвдөд хийсэн «шинэчлэлийн» бодлогод төвдийн тариачдаас гадна сүм хийд, сүсэгтэн олон түмэн хүчтэй нэрвэгдсэн юм. Бээжин сүм хийдийн хэвийн ажиллагааг хүндэтгэх тухай амлалтаасаа нэгэнт няцаж ялангуяа 1959 оны бослогыг дарсны дараа сүм хийдийн эдийн засгийн үндсийг таслах, улс төрийн ролийг нь үгүй хийх кампанит ажлыг харгис хэрцгий аргаар явуулжээ. Сүм хийд, лам нарын тоо эрс цөөрч Гумбуны 3000 ламаас 1962 онд 400, Дрэбунгийн 8-10 мянган ламаас дөнгөж 700 үлдэж (108-р тал) олон арван сүм дуган хаагдан лам нарыг нь зам гүүр барих «нийгэмд» тустай биеийн хөдөлмөрт шилжүүлжээ. «Шинэчлэлийн» жилүүдэд Төвдийн олон зуун жилийн түүх соёлын дурсгалт ховор нандин зүйлүүдийг хятадад зөөн авчирч, заримыг нь газар дээр нь устгажээ. Тийнхүү Төвдийн соёл шашныг «харгис бурунгуй» хэмээн зарлажээ. Төвдийн үндэсний хэл, соёлыг устгах ажлыг Төвдөд маогийн үзэл санаа, хятад хэлийг өргөн дэлгэрүүлэх кампанит ажилтай хослуулан явуулж байсан тухай зохиогч номдоо дэлгэрэнгүй бичсэн байна (130-р тал).

Төвдийн тухайн цаг үеийн онцлог байдлаас болж энэ автономит районд «соёлын хувьсгал» өвөрмөц байдалтай явагдсан бөгөөд түүний гол зорилго нь Төвдөд Хятадын цэрэг-засаг захиргааны байгууллагыг цэгцлэн байгуулах, хөдөө аж ахуйг нь хятадын загвараар «коммун»-д оруулах, нутгийн уугуул ард түмнийг маогийн үзэл санаагаар зэвсэглэхэд оршиж байжээ. Төвдийг тийнхүү нийгэм-эдийн засгийн талаар хятадчилсаны дүнд тэнд маоист цэрэг-хүнд суртал, дарангуйллын аппаратыг бэхжүүлж болно гэж Бээжингийнхэн тооцоолж байсан байна. Гэвч Бээжин Төвдийн нийгмийн янз бүрийн давхаргын зүгээс урьдын адил эсэргүүцэлтэй тулгарч зарим газарт зэвсэгт мөргөлдөөн болдог байлаа. Хятадыг эсэргүүцсэн Төвдийн хөдөлгөөн партизаны отрядад хүртэл нэгдэж, нууц байгууллагууд ажиллаж байсан байна (149—152-р тал). Хэрэв «соёлын хувьсгалын» явцад ард түмний аж байдал улам доройтож тэдний наад захын эрх бүдүүлгээр зөрчигдөж, Төвдийн үндсэн хуульт засаг төрийн байгууллага устгагдаж, Төвдийн соёл урлаг уналтын туйлд хүрсэн бол 70-аад оны үед Бээжингийн маоист эрх баригчдын их гүрний үндсэрхэх дээрэнгүй үзэл бодлого улам газар авч Төвдийг бүхэлд нь цэргийн нэгэн томоохон хуаран болгон хувиргаж түүнийг улмаар хөрш зэргэлдээ Өмнөд Азийн орнуудын эсрэг Бээжингээс явуулах жанжлах бодлогодоо цэрэг-эдийн засгийн түшиц болгож байгааг зохиогч

тодорхой жишээ баримтаар илчлэн бичсэн байна. Энэ зорилгоор Төвдөд ХАЧА-ийн 400 гаруй мянган цэрэг байрлуулахын зэрэгцээгээр хөдөлмөрийн чадвартай бүх иргэд өрхийн цэрэгт алба хааж (177-р тал) олон зуун мянган тариачид, хөдөөгийн малчид цэргийн барилга байгууламж дээр ажиллаж байна.

Хятадын төв засгийн газрын удаа дараагийн заалт заавар, Төвдөд байрлаж байгаа ХАЧА-ийн хүчинд тулгуурласан хятадын их гүрний үндсэрхэх дээрэнгүй бодлого Төвд орныг БНХАУ-ын бүрэлдэхүүнд нэгтгэн нийлүүлж энэ автономит районы нийгэм-эдийн засгийн бүтцийг хятадын буюу маогийн загварт оруулахад Төвдийн ард түмний үндсэн эрх, үндэсний онцлогийг бүдүүлгээр зөрчих замаар хүрсэн гэж зохиогч эцэст нь дүгнэжээ.

В. А.. Богословскийн шинэ ном нь БНХАУ дахь хятад бус үндэстэн ястны өнөөгийн байдлыг ойлгон мэдэхэд онол практикийн болон эрдэм шинжилгээний чухал ач холбогдолтой дорвилог бүтээл болжээ.

Д. Пүрэв